

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ ОРНЫ ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН АСУУДАЛ

№40

Улаанбаатар 2019

| | |
|---|-----|
| Отгонтэнгэрийн УТХГ-ын ойн төлөв байдал ба ойн менежментийн сайжруулах асуудалд Д.Ганбат • П.Баттулга • Д.Баттогтох • Ц.Дашзэвэг • Н.Цагаанцоож | 218 |
| Монгол орны зарим нэг сумдын төвүүдийн цэвдэг ба инженерийн байгууламжийн өнөөгийн байдал А.Дашцэрэн • Я.Жамбалжав • Х.Тэмүүжин • Г.Цогтэрдэнэ • Г.Уламбаяр | 227 |
| Тариалангийн хөрсний шинж чанар, органик нүүрстөрөгчийн өөрчлөлт Д.Ихбаяр • Х.Золжаргал | 236 |
| Түймэрт өртсөн болон навч шилмүүсний шавжинд идэгдэж хатсаны дараах ойд тархах модлог идэшт шавж Б.Батчөдөр • Н.Цагаанцоож • Д.Ганбат | 243 |
| Шишхэд голын сав газрын ургамлын аймаг, ургамалалжилтын судалгааны зарим үр дүнгээс Э.Үүрийнцолмон | 250 |
| ХАА-н газар ашиглалтын хэлбэрүүд хөрсний шинж чанарт нөлөөлөх нь Р.Дэлгэрцэцэг • Г.Баярбат • Ө.Билгүүн • Н.Золзаяа, Я.Баасандорж | 255 |
| Хөдөө аж ахуйг салбарын экосистемийн хангамжийн үйлчилгээг "Market Price" аргаар үнэлэх асуудалд Т.Пүрэвсүрэн • Э.Авирмэд • С.Энх-Амгалан | 265 |
| Монголын зүүн бүс нутаг дахь хөгжлийн ирээдүй сайтай сумдыг орон зайн анализаар тодорхойлох нь Б.Хэрлэнбаяр • Б.Нацагсүрэн • Ш.Амангүл | 274 |
| Зам дагуух бүс нутаг нь хүн амын нутагшилтын голомт нутаг болох нь Ц.Отгонхүү • П.Цэенханд • Н.Одхүү | 282 |
| Агро-уур амьсгалын нөхцөл газар тариалангийн үйлдвэрлэлд нөлөөлөх нь (Сэлэнгэ аймгийн баруун сумдын жишээн дээр) В.Баярмаа • С.Энх-Амгалан • Э.Авирмэд | 289 |
| Улаан тайгын УТХГ-ын ойн сангийн төлөв, менежментийн асуудалд Г.Батсайхан • Д.Батдорж • Б.Батчөдөр • О.Батцэцэг • П.Баттулга | 297 |
| Зэт Хантай Бүтээлийн нурууны ДЦГ-ын ойн сангийн төлөв менежментийн асуудалд Д.Батдорж • Г.Батсайхан • П.Баттулга • Б.Батчөдөр | 305 |

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭКОСИСТЕМИЙН ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ “MARKET PRICE” АРГААР ҮНЭЛЭХ АСУУДАЛД (Өмнөговь аймгийн жишээгээр)

М.Пүрэвсүрэн, Э.Авирмэд**

*ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Физик газарзүйн салбар
Э-Шуудан: geo.purevsuren@gmail.com

Abstract

The purpose of this study is to evaluate the contribution of the ecosystem services to the agricultural sector by economic evaluation. The study based on the “market price method” and total agricultural production output estimated by using an instruction of calculating "Gross Domestic Product" issued by National statistical office to assess the value of ecosystem provisioning services in the agricultural sector of Umnugobi aimag. As a result of the study, the contribution of the ecosystem provisioning service to the livestock sector in Umnugobi aimag and its economic value reached 43.7 billion MNT in 2017, which is increased by 6.5 billion MNT (17.4 percent) compared to the previous year. The contribution of the ecosystem services to the crop production has increased by 30.5 million MNT from the previous year and reached at 662.5 million MNT in 2017. By defining the value of ecosystem services in key economic sectors, it is important to provide scientifically based data and information on the development of project and plans for aimed at ecosystem conservation, rehabilitation and sustainable use of natural resources.

Түлхүүр үг: Экосистемийн хангамжийн үйлчилгээ, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, Эдийн засгийн үнэлгээ, Зах зээлийн үнийн арга

Оршил


Мянганы экосистемийн үнэлгээний байгууллагийн (Millennium ecosystem assessment) тодорхойлсноор “экосистемийн үйлчилгээ гэдэг бол хүмүүсийн экосистемээс хүртэж буй хувь нэмэр, үр ашиг” бөгөөд зохицуулах, хангамжийн, дэмжих болон соёлын гэсэн хэлбэрүүдтэй (Polasky, 2009). Экосистемийн үйлчилгээний талаархи ойлголт анх 1970-аад оны сүүл үед үүссэн (Erik Gomez-Baggethun, 2010). 1980-аад онд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг тодорхойлох чиглэлээр хөгжиж (WCED, 2010), 1990 оноос судалгаа, шинжилгээний ажилд уг ойлголтыг ашиглах болж түүний хувь нэмрийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэх аргагүй хөгжиж эхэлсэн (Costanza, 1997). Хөдөө аж ахуйн салбар нь тоос хүртээлт, бэлчээрийн шимт ургамал, гадаргын болон гүний ус, тэжээлийн бодис, хөрсний үржил шим, чийг, нарны гэрэл, дулаан зэрэг экосистемийн зохицуулах болон дэмжих үйлчилгээг хүртэснээр хүн төрөлхтөнийг хоол хүнс, түүхий эд материал зэргээр хангах хангамжийн үйлчилгээг үзүүлдэг. Экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэр гэдэг нь экосистемээс бүтээгдэхүүн байдлаар хүний хүртэж буй үр ашиг юм (Millennium ecosystem assessment, 2005).

Судалгааны зорилго нь Монгол орны байгалийн бүсүүдийн ландшафтын экологийн чадавхийн үнэлгээг тооцох сэдэвт ажлын хүрээнд цөлжүү хээрийн бүслүүрт хамаарагдах Өмнөговь аймгийг судалгааны талбайгаар сонгон авч хөдөө аж ахуйн салбарт оруулж буй экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийн хувь нэмрийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэн дүгнэхэд оршино. Экосистемийн үйлчилгээний хувь нэмрийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэхэд зах зээлийн болон зах зээлийн бус үнийг ашиглан илэрхийлэх гэсэн ойлголт байдаг. Зах зээлийн үнийг ашиглан илэрхийлэх гэдэг нь бараа бүтээгдэхүүн байдлаар зарагдаж, худалдаалагдаж болох экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийг үнэлэхэд ихэвчлэн ашиглагддаг (Department for environment, food and rural affairs, 2009). Зах зээлийн бус үнийн аргаар шууд арилжаалагдах боломжгүй, зах

зээлийн үнээр үнэлэх боломжгүй экосистемийн соёлын болон зохицуулах үйлчилгээний хэлбэрийн хувь нэмрийг үнэлэхэд ашигладаг.

Судалгааны арга зүй, боловсруулалт

1 дүгээр бүдүүвч: Экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг тооцох аргазүй (Pagiola, 2004), (Griffin, 2007)



‘Market price’ арга.

Зах зээлийн бүтээгдэхүүнд ихээхэн хувь нэмэр оруулдаг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийг эдийн засгийн үнэлгээгээр илэрхийлэхэд ‘market price’ үнэлгээний аргыг голчлон ашигладаг (Department for environment, food and rural affairs, 2009). ‘Market price’ арга нь ихэнхи тохиолдолд экосистемийн үйлчилгээг үнэлэх анхдагч арга гэдгийг судлаачид хүлээн зөвшөөрдөг (Rebecca, 2003). Гэсэн хэдий ч зах зээлийн үнийн аргыг ашиглахын тулд байгалиас хамааралгүй татвар, нэмэгдэл хөрөнгө оруулалт зэргийн бусад зардлыг үнэн зөв тодорхойлж (Barbier, 1997), тухайн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд оруулсан бусад бүх зардлын хувь нэмрийг зайлшгүй тооцон үзэх шаардлага тулгардаг (Cairns, 2002).

Уг арга нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн хэмжээ, үйлдвэрлэхэд зарцуулсан үйлдвэрлэгчийн зардлуудад үндэслэн бүхий л төрлийн зах зээлд борлуулагддаг экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийг үнэлэхэд ашиглагдаж болохоос гадна үер, цаг уурын гамшигт үзэгдлээс хамгаалах зэрэг зохицуулах үйлчилгээний хэлбэрийг үнэлэхэд мөн ашиглагдаж байна (Freeman, 1991). ‘Market price’ аргыг ашиглан экосистемийн үйлчилгээний хувь нэмрийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэхэд (1) экосистемийн зохицуулах, дэмжих үйлчилгээг хүртэж буй зорилтот салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нийт хэмжээг тодорхойлох, (2) тус тодорхойлогдсон бүтээгдэхүүний зах зээлийн үнийн талаархи мэдээллийг цуглуулах, (3) бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийн хэмжээ болон тухайн оны зах зээлийн үнэд үндэслэн нийт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний үр ашгийг мөнгөн үнэлгээгээр тооцох, (4) тус гаргасан үнэлгээнээс менежментийн (management cost), нөхцөл-боломжийн (opportunity cost) болон бусад төрлийн үйл ажиллагааны зардлыг багтаасан ‘Avertive expenditure’ буюу нийт зарцуулсан зардлыг хасах гэсэн 4 үе шатын дагууд тодорхойлдог (Lucy Emerton, 2009).

Зорилтот салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нийт хэмжээг тодорхойлох: Судалгааны ажлын хувьд зорилтот салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл буюу Өмнөговь аймгийн хүрээнд хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тооцоход Үндэсний статистикийн хорооны аргачлал (ҮСХ, 2017)-ын дагууд 2012-2017 оны хугацаан дахь статистик мэдээллийг ашиглан сүү-сүүн бүтээгдэхүүн, ноос-ноолууран

бүтээгдэхүүн, мах, арьс ширний үйлдвэрлэл болон бэлтгэсэн хадлан, тэжээл, төмс, хүнсний ногооны хэмжээг тооцов.

- Сүү үйлдвэрлэлийн хэмжээг тооцоход тухайн жилд бойжуулсан нийт төлийн тоонд үндэслэн, төлтэй эх малын тоог тооцоолж, (ҮСХ, 2017) судалгааны үр дүнд тооцоологдсон эх малын саалинд хамрагдалтын түвшин, 1 малын сүүний жилийн дундаж гарцын үзүүлэлтүүдийг ашиглан нийт сүүний үйлдвэрлэлийг тн-оор гаргав.
- Ноос, ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээг тооцоход оны эхний нийт малын тоо болон зүй бусаар хорогдсон малын тоог суурь үзүүлэлтээр авч ноос ноолуурыг нь авсан малын тоог гарган, 1 малын ноос, ноолуурын жилийн дундаж гарцын утгыг ашиглан нийт үйлдвэрлэлийн хэмжээг тн-оор гаргав.
- Мах үйлдвэрлэлийн хэмжээг тооцоход хэрэглээнд зарцуулсан малын тоог суурь үзүүлэлтээр авч нэг малын махны гарцын утгыг (Ганзориг, 2015) (адуу-махны гарц нь дунджаар 77 кг, үхэр-махны гарц нь дунджаар 123 кг, хонь-махны гарц нь дунджаар 16 кг, ямаа- махны гарц нь дунджаар 12 кг) ашиглан нийт үйлдвэрлэлийн хэмжээг тн-оор гаргав.
- Арьс ширний үйлдвэрлэлийн хэмжээг тооцоход хүнсний хэрэглээнд зарцуулсан нийт мал, хорогдсон малын тоо болон арьс, шир ашиглалтын хувийг тооцсоноор (хэрэглээнд зарцуулсан нийт малын тооноос 100%, зүй бус хорогдсон малын тооноос адуу-60%, үхэр-65%, хонь-65%, ямаа-60%) (Уран, 2015) нийт ашиглагдсан арьс, ширний хэмжээг ширхэгээр тооцож гаргав.


Зах зээлийн үнийн талаархи мэдээллийг цуглуулан, нийт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний үр ашгийг мөнгөн үнэлгээгээр тооцох: Зорилтот салбарын бүтээгдэхүүний 2012-2017 онуудын зах зээлийн үнийн талаархи мэдээлэл, тоо баримтыг статистикийн мэдээллийн нэгдсэн сан, монгол улсын статистикийн эмхэтгэлүүд, аймгийн статистикийн жилийн эцсийн тайлангууд зэрэг эх сурвалжуудаас авч уг судалгаанд ашиглав.

‘Avertive expenditure’ буюу нийт зарцуулсан зардлыг тооцох. ҮСХ-оос явуулсан 21 аймгийн 1120 мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхөөс ярилцлагын болон асуулга судалгааны аргаар авсан анхдагч мэдээлэлд үндэслэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэлтийн нийт ашиг алдагдлын хувийг тодорхойлсон улсын анхдугаар тооллогын судалгааны үр дүнг ‘Avertive expenditure’ буюу нийт зарцуулсан зардал гэж авч үзэн судалгаандаа ашиглах замаар тухайн салбарт оруулж буй экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийн хувь нэмрийг тооцов. Хөдөө аж ахуйн салбарт оруулж буй экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэхэд ажиллах хүч, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, дэд бүтцийн асуудлуудыг шийдэхэд зарцуулж буй “management” зардлууд, тухайн аж ахуйг эрхлэхэд шаардлагатай болон эрхлэснээс хүртсэн ашгаас тооцогдох ёстой газар, зээл зэргийн татваруудад хамаарах “opportunity” зардлууд (Oliver and William. 2009), үр тариа, тэжээл бордоо, түүхий эд материал, хамгаалалтанд зарцуулах зардлуудыг багтаах шаардлагатай (Anne and John, 1998). Уг судалгаанд завсрын хэрэглээний зардалд тэжээл, үр бордоо, хортон шавж устгал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, шатахуун, цахилгаан эрчим хүч, дулаан, тээвэр, машин тоног төхөөрөмжийн түрээс зэргийг ашиглахад зарцуулсан зардлуудыг багтаасан. Харин нэмэгдэл өртгийн зардлын хувьд цалин, шагнал урамшуулал, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, бэлчээр, газар ашигласны төлбөр, малын албан татвар, өөрийн эзэмшлийн авто тээвэр болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн татвар зэрэг бусад албан татвар, хураамжийн зардлуудыг хамруулсан тул уг ашиг алдагдлын зардлын дүнг судалгаандаа ашиглах нь нийцтэй юм. Эдгээр зардлуудыг нэгтгэн тооцсоны үр дүнд хөдөө аж ахуйн салбарыг эрхлэхэд зарцуулах нийт зардлын хувь мал аж ахуйн


салбарын хувьд 58.9%, газар тариалангийн салбарын хувьд 28.8% гэж тооцоологдсон (ҮСХ, 2011).

Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнгээс үзэхэд мал аж ахуйн салбарын хувьд 2017 онд нийт 11.9 тэрбум төгрөг бүхий сүү, 40.1 тэрбум төгрөг бүхий ноос, ноолуур, 4.9 тэрбум төгрөг бүхий арьс, шир, 17.3 тэрбум төгрөг бүхий мах (нядалгааны жингээр) бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оны үзүүлэлтээс тус бүр 13.6-17 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мал аж ахуйгаас гарах бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр Номгон сум аймагтаа тэргүүлнэ.



1 дүгээр зураг. Өмнөговь аймгийн мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 2017 он
Газар тариалангийн салбарын хувьд 2017 онд 190.3 га талбайд тариалалт хийсний 82 га талбайд төмс, 82.8 га талбайд хүнсний ногоо, 25.5 га талбайд тэжээлийн ургамал тариалж 585.3 тонн төмс, 724.0 тонн хүнсний ногоо, 215.1 тонн тэжээлийн ургамал хурааснаас (Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс, 2017) тус аймгийн хэмжээнд Даланзадгад, Булган, Цогтцэций сумдууд газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр тэргүүлж, нийт үйлдвэрлэлтийн хагас хувийг бүрдүүлж байна.



2 дүгээр зураг. Өмнөговь аймгийн газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 2017 он

Судалгааны үр дүнгээр тодорхойлогдсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээг тус аймгийн хүрээнд төрөл тус бүрээр нь авч үзэн өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлтийн хэмжээтэй харьцуулан, өсөлтийн хувийг тооцож үзэхэд дараах дүгнэлтүүдэд хүрч байна.

- Сүүний хувьд 11.9 тэрбум төгрөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь нийт ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 15.6%-ийг бүрдүүлж өмнөх оноос 26.4%-иар нэмэгдсэн.
- Ноос ноолуурын хувьд 40.1 тэрбум төгрөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь нийт ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 52.5%-ийг бүрдүүлж өмнөх оноос 13.6%-иар нэмэгдсэн.
- Арьс шир хувьд 4.9 тэрбум төгрөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь нийт ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 6.4%-ийг бүрдүүлж өмнөх оноос 17.6%-иар нэмэгдсэн.
- Мах хувьд 17.3 тэрбум төгрөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь нийт ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 22.6%-ийг бүрдүүлж өмнөх оноос 20.8%-иар нэмэгдсэн.
- Газар тариалангийн хувьд 2.2 тэрбум төгрөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь нийт ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2.8%-ийг бүрдүүлж өмнөх оноос 5.0 %-иар буурсан үзүүлэлтүүдийг тус тус үзүүлж байна.

1 дүгээр хүснэгт. Өмнөговь аймгийн хөдөө аж бүтээгдэхүүн үйлдвэрлэл
2017 он, тэрбум төгрөг (сумаар)


| № | Бүс | Сумын нэр | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний төрөл | | | | | | | | | | Нийт үйлдвэрлэсэн ХАА-н бүтээгдэхүүн, 2017 он (Тэрбум төгрөг) |
|--|--------|-------------|-------------------------------------|------|----------|------|---------------|------|----------|------|-----------|--------------|---|
| | | | Газар тариалан | | Сүү | | Ноос, ноолуур | | Мах | | Арьс, шир | | |
| | | | Тэр. төг | % | Тэр. төг | % | Тэр. төг | % | Тэр. төг | % | Тэр. төг | % | |
| 1 | Баруун | Ноён | 0.05 | 2.2 | 0.42 | 3.5 | 2.36 | 5.9 | 0.83 | 4.8 | 0.30 | 6.1 | 3.95 |
| 2 | | Гурвантэс | 0.14 | 6.5 | 0.99 | 8.3 | 3.95 | 9.8 | 1.42 | 8.2 | 0.49 | 9.8 | II. 6.99 |
| 3 | | Сэврэй | 0.07 | 3.2 | 0.81 | 6.7 | 3.02 | 7.5 | 1.13 | 6.5 | 0.44 | 8.8 | 5.46 |
| 4 | Зүүн | Ханбогд | 0.05 | 2.1 | 0.72 | 6.0 | 2.26 | 5.6 | 0.95 | 5.5 | 0.18 | 3.6 | 4.15 |
| 5 | | Цогтцэций | 0.25 | 11.3 | 0.61 | 5.1 | 1.66 | 4.1 | 0.47 | 2.7 | 0.08 | 1.7 | 3.08 |
| 6 | | Манлай | 0.10 | 4.6 | 0.87 | 7.3 | 2.32 | 5.8 | 1.51 | 8.7 | 0.28 | 5.7 | 5.08 |
| 7 | | Баяновоо | 0.08 | 3.6 | 0.71 | 5.9 | 2.11 | 5.3 | 1.01 | 5.8 | 0.20 | 4.1 | 4.11 |
| 8 | Төв | Ханхонгор | 0.20 | 9.0 | 1.05 | 8.8 | 3.48 | 8.7 | 1.04 | 6.0 | 0.34 | 6.8 | III. 6.10 |
| 9 | | Цогтовоо | 0.07 | 3.4 | 0.69 | 5.8 | 1.78 | 4.4 | 0.80 | 4.6 | 0.21 | 4.3 | 3.55 |
| 10 | | Мандаловоо | 0.09 | 4.0 | 0.87 | 7.3 | 2.51 | 6.3 | 1.40 | 8.1 | 0.36 | 7.4 | 5.24 |
| 11 | | Булган | 0.33 | 15.3 | 1.04 | 8.7 | 2.58 | 6.4 | 1.53 | 8.8 | 0.36 | 7.3 | 5.85 |
| 12 | | Даланзадгад | 0.51 | 23.4 | 0.61 | 5.1 | 1.68 | 4.2 | 0.87 | 5.0 | 0.24 | 4.9 | 3.92 |
| 13 | | Хүрмэн | 0.05 | 2.3 | 0.69 | 5.7 | 2.43 | 6.0 | 1.24 | 7.2 | 0.40 | 8.1 | 4.80 |
| 14 | | Баяндалай | 0.11 | 4.9 | 0.66 | 5.5 | 3.03 | 7.5 | 1.16 | 6.7 | 0.40 | 8.1 | 5.35 |
| 15 | | Номгон | 0.10 | 4.4 | 1.21 | 10.1 | 4.96 | 12.4 | 1.98 | 11.4 | 0.66 | 13.4 | I. 8.91 |
| Аймгийн хэмжээнд нийт үйлдвэрлэсэн ХАА бүтээгдэхүүн, тэрбум төгрөгөөр | | | | | | | | | | | | 76.55 | |

Өмнөговь аймгийн хэмжээнд ямааны сүү, ноолуур, арьс, махны төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт бусад малаас авах ашиг шимийн бүтээгдэхүүнээс илүү өндөр байх бөгөөд аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээгээр Номгон сум тэргүүлж байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн, уул уурхайн хөгжлийн гараанд тулгуурлан нийгмийн хөгжлийг түргэтгэх, дэвшилд хүргэх, аймгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах зорилтуудыг

агуулан Өмнөговь аймгийн засаг даргын тамгийн газраас “2010-2020 он хүртэлх Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан. Уг хөтөлбөрт тусгагдсанаар тус аймаг төв, зүүн, баруун гэсэн 3 бүсэд хуваагдсан (Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газар, 2009). Иймд тухайн аймгийн хэмжээнд экосистемээс хүртэж буй хангамжийн үйлчилгээний хэлбэрийг үнэлэн, дүгнэлт гаргахад тус 3 бүсийн дагууд авч үзэв.

1 дугаар график. Өмнөговь аймгийн хэмжээнд экосистемийн хангамжийн үйлчилгээний ХАА-н салбарт оруулж буй хувь нэмэр, түүний эдийн засгийн үнэлгээ, тэрбум төгрөг
(а) Мал аж ахуйн салбар (б) Газар тариалангийн салбар (в) ХАА-н салбар (нийт)



1 дугаар графикаас харахад Өмнөговь аймгийн хэмжээнд экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийн мал аж ахуйн салбарт оруулж буй хувь нэмэр 2017 онд 43.7 тэрбум төгрөг бөгөөд уг үзүүлэлт нь өмнөх оныхтой харьцуулахад 6.5 тэр.төгрөгөөр буюу 17.4%-иар нэмэгдэж, 5 жилийн өмнөх үетэй харьцуулвал 14.7 тэр.төгрөгөөр буюу 58.3%-иар өссөн нь ажиглагдаж байна. Харин газар тариалангийн салбарт оруулж буй экосистемийн хангамжийн үйлчилгээний хэлбэрийн хувь нэмэр 2017 онд 662.5 сая төгрөгт хүрч өмнөх оноос 30.5 сая.төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хэлэлцүүлэг

Монгол улсын үндэсний статистикийн хорооноос жил бүр “Хөдөө аж ахуйн салбар”-ын танилцуулгыг эрхлэн гаргадаг. Уг танилцуулгад мал аж ахуй болон газар тариалангийн салбарын мэдээллийг улсын дүн болон эдийн засгийн баруун, хангайн, төв, зүүн гэсэн бүсүүд, Улаанбаатар хотын хэмжээнд нэгтгэн гаргадаг тул тухайн сонгосон аймгийн сумдын түвшинд хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийг нарийвчлан тооцсон мэдээ, баримт байдаггүй болно. Монгол орны байгалийн бүсүүдийн ландшафтын экологийн чадавхийн үнэлгээг тооцох сэдэвт ажлын хүрээнд ландшафтийн экологийн эдийн засгийн чадавхийг тооцох дэд сэдвийн хүрээнд байгалийн бүс, бүслүүрээс гарах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртөгт суурилсан байгалийн үр ашгийг тооцоход энэхүү судалгааны ажлын аргазүй болоод үр дүнд үндэслэн хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийг тооцох, бүс нутгийн хэмжээнд харьцуулалт хийн үнэлэлт дүгнэлт гаргахад чухал ач холбогдолтой.

Дүгнэлт

Судалгаанд үндэсний статистикийн хорооноос боловсруулсан “Дотоодын нийт бүтээгдэхүүн тооцох аргачлал”-ын дагууд Өмнөговь аймгийн хөдөө аж ахуйн салбарын

бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг сум тус бүрээр тооцоолж, түүнд нөлөөлж буй экосистемийн хангамжийн үйлчилгээний хувь нэмрийг үнэлэхэд 'Market price' зах зээлийн үнийн аргыг ашиглав. 'Market price' зах зээлийн үнийн аргыг ашиглахад нийт үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн хэмжээ, завсрын хэрэглээний болон нэмэгдэл өртгийн зардлын хувь зэрэгт үндэслэв. Судалгааны үр дүнгээс үзэхэд 2017 онд хөдөө аж ахуйн салбарт оруулсан экосистемийн хангамжийн үйлчилгээний 31.5%-ийг Өмнөговь аймгийн төвийн бүсийн нутгийн хойд хэсэгт байрлах Ханхонгор, Булган, Мандаловоо, Цогтовоо сумд болон аймгийн төв Даланзадгад хот, 25.2%-ийг нутгийн өмнөд хэсэгт байрлах Хүрмэн, Баяндалай, Номгон сумдууд, мал аж ахуйн салбарын чиглэлээр Номгон, Гурвантэс сумдууд, газар тариалангийн чиглэлээр Даланзадгад хот, Булган сум экосистемийн хангамжийн үйлчилгээг илүүтэй хүртэж байна.

Талархал

Судалгааны мэдээ материал, өгөгдлийг физик газарзүйн салбарын “Монгол орны байгалийн бүсүүдийн ландшафтын экологийн чадавхийн үнэлгээг тооцох” сэдэвт ажлын хүрээнд цуглуулсан бөгөөд үнэтэй санал зөвлөмж, шүүмж өгсөн доктор С.Энх-Амгалан болон сэдвийн удирдагч доктор Э.Авирмэд, тус салбарын хамт олонд талархал илэрхийлье.

Ашигласан ном, хэвлэл

1. Stephen Polasky., 2009. Integrating ecology and economics in the study of ecosystem services: Some lessons learned.
2. Erik Gomez-Baggethun., 2010. The history of ecosystem services in economic theory and practice: From early notions to markets and payment schemes.
3. WCED., 2010. Our common future. World commission on environment and development
4. Robert Costanza., 1997. The value of the world's ecosystem services and natural capital
5. Millennium ecosystem assessment. 2005. Ecosystems and human well-being: Synthesis. Island Press. Washington DC.
6. Department for Environment, Food and Rural Affairs., 2009. An introductory guide to valuing ecosystem services. United Kingdom.
7. Stefano Pagiola and Konrad von Ritter., 2004. Assessing economic value of ecosystem conservation, The world bank environment document.
8. Shan Ma and Robert Griffin., 2007. Ecosystem service valuation: Concepts, Methods and applications, Stanford university
9. Rebecca M. Carson., 2003. A review of Ecosystem valuation techniques. The university of Georgia
10. Barbier.B., Acreman M.C. and Knowler, D. 1997. Economic valuation of wetlands: A guide for policy makers and planners. Ramsar Convention Bureau, Glend, Switzerland
11. Cairns., 2002. The use of market prices within green accounting to assessing ecosystem services
12. Freeman A., 1991. Valuing environmental resources under alternative management regimes
13. Lucy Emerton., 2009. An integrated wetland assessment toolkit (A guide to good practise). IUCN
14. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо., 2017. Дотоодын нийт бүтээгдэхүүн тооцох аргачлал, Улаанбаатар.
15. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо., 2017. Хөдөө аж ахуйн түүвэр судалгаа, Улаанбаатар.

16. Ганзориг.Г., 2015. Хан Хэнтийн дархан цаазат газрын экосистемийн үйлчилгээний салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ, Улаанбаатар.
17. Уран.Х., 2015. Махны нийлүүлэлтийн сүлжээнд хорогдлыг бууруулах арга зам, Улаанбаатар.
18. Oliver Springate-Baginski, David Allen and William Darwall., 2009. An integrated wetland assessment toolkit (A guide to good practise) IUCN.
19. Anne M.Alexander, John A.List., 1998. A method for valuing global ecosystem services. Elsevier-Ecological economics journal-27.
20. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо., 2011. Хөдөө аж ахуйн улсын анхдугаар тооллого, Улаанбаатар.
21. Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс., 2017. Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн байдал, Даланзадгад.
22. Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газар., 2009. Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он).